

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

Амьс дугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО,
АДХ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ СОНИН.

14 дахь жилд 5(1149)	1962 оны 1 дүгээр сарын 22	ДАВАА
-------------------------	-------------------------------	-------

Улсын тэргүүний ухуулагч, суртал
нэвтрүүлэгчдийн анхдугаар
зөвлөлгөөний материалыг судлан
сурталчилж байна

Аймгийн намын хороо, улсын тэргүүний ухуулагч, суртал нэвтрүүлэгчдийн зөвлөлгөөний шийдвэрийг биелүүлэх төлөвлөгөө гаргаж өгөж ажлыг эрч далайцтай зохиож байна.

Улсын тэргүүний ухуулагч, суртал нэвтрүүлэгчдийн зөвлөлгөөний дүнгийн тухай ярианы сэдэв гаргаж төв орон нутгийн намын байгууллага, ухуулагчдаас хөдөлмөрдөд унших, гарсан тэргүүний туршлага, дөвшилт аргыг нийт ухуулагчдад эзэмшүүлэх зорилт тавьж байна.

Улсын тэргүүний ухуулагч, суртал нэвтрүүлэгчдийн анхдугаар зөвлөлгөөнд оролцсон нөхөр Мянганбуу, Алтантөрөл нар аймгийн төвийн намын үүрийн нарийн бичгийн дарга нар, дугуйлангийн суртал нэвтрүүлэгчид, ухуулагч нартай уулзаж байна.

Эдгээр нөхөд зөвлөлгөөний дүн, өөрсдийн сэтгэгдэл цаашид хийх ажлын тухай ярьж, хөдөө дахь ухуулагч, суртал нэвтрүүлэгч нарт захидал илгээлтүүдийг явуулжээ.

Ухуулагч Алтантөрөл, ухуулагч хүн юуны өмнө мөдөөл зохих зүйл, зайлшгүй дагаж биелүүлэх журам дэглэмийг бичиж төв хөдөөгийн ухуулагч нарт хүргүүлэхээр бэлтгэжээ.

Ухуулагч Гөндөв, Жамъян, Хөмдөх, Буджав нар өөрсдийн нэгдэл, сангийн аж ахуй, зэргэлдээ сумын хөдөлмөрчидтэй уулзах ажил зохиож байна.

Эдгээр уулзалт цуглаанууд нь улсын тэргүүний ухуулагч, суртал нэвтрүүлэгчдийн зөвлөлгөөний материалыг судлан сурталчлах, малаа тарган онд оруулах, гарсан төлбөр бүрийг хорогдолгүй бойжуулах

ажилтай нягт хослон ухуулга таниулыг улам эрчимтэй болгох зорилгын дор болж байна.

Үүний дүнд Баянзүрх, Эрдэнэ, Угтаалцайдам зэрэг сумд төлийн бэлтгэлийг хангах, төл хүлээн авах ажилд бүх нийтийг өргөн оролцуулж төлийг хөрөвжилтийн үе шатаар бойжуулахад тохирсон хашаа барих зэрэг ажлыг шуурхай хийж байна.

18 аймаг, Улаанбаатар хотын намын байгууллагуудын ухуулагч, суртал нэвтрүүлгийн ажилд гарч байгаа туршлагаудын тухай лекци, ярианы сэдэв, ном товхимол, альбом, ухуулах хуудас зэрэг 100 шахам материалыг аймгийн төвийн намын үүрүүдийн гишүүдэд судлуулсан ажилдаа нэвтрүүлэн, ном болгон, намын анхан шатны үүр, хороол, нийт ухуулагчдад хүргүүлэх ажил зохиож байна.

Увс аймгийн ухуулагч Нүрээд, Булганы Дашцэрэн, суртал нэвтрүүлэгч Мянганбуу, Санжаа, Дармаа нарын зэрэг ухуулагч, суртал нэвтрүүлэгчдийн ажилдаа хэрэглэдэг арга барил, уран чадварыг ухуулагч, суртал нэвтрүүлэгчдэд эзэмшүүлэхийн тулд сургууль семинаруудад тусгай программаар зааж өглөө.

Одоогийн шатанд намын үзэл суртлын ажлыг социалист байгуулалтын шинэ зорилттой холбон эдгээр зорилтыг биелүүлэх тэмцэлд хөдөлмөрчдийг дайчлан зохион байгуулах явдал юу, юунаас илүү чухал зүйл болж байна.

Энэ зорилтыг биелүүлэхийн тулд ухуулга, суртал нэвтрүүлгийн ажилд гарч байгаа тэргүү ий туршлагыг өргөн ашиглаж, үр дүнг улам тодорхой болгох хэрэгтэй.

Аймгийн ХЗЭ-ийн Х бага хурлын сонсгол мэдээ

Аймгийн ХЗЭ-ийн 10 дугаар бага хурал 1962 оны 1 дүгээр сарын 22-н өдөр аймгийн төвд хуралдаж.

Аймгийн ХЗЭ-ийн 10 дугаар бага хуралд аймгийн ХЗЭ-ийн хорооны тайлан, шалган байцаах комиссын тайлан, мачдатын комиссын илтгэлүүдийг хэлэлцэж, уг илтгэлд гарсан тогтоолуудыг бага хурлынхан санал нэгтгэй батлав.

Тус бага хуралд МХЗЭ-ийн Төв Хорооны нэрийн бичгийн дарга нөхөр Барамсай оролдож дэлгэрэнгүй үг хэлэв.

Бага хурал зохион байгуулалтын асуудал хэлэлцэж МХЗЭ-ийн 14 дүгээр их хурлын төлөөлөгчөөр МХЗЭ-ийн гишүүн, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Сандагдалай, Цэрэн-Очир, хоньчин Цэрмаа, төмөрчин Цэнд нарын 31 хүн, аймгийн ХЗЭ-ийн хорооны бүгд хурлын бүрэлдэхүүнийг 55 хүнээр сонгов.

Аймгийн ХЗЭ-ийн хорооны анхдугаар бүгд-хурал болж Аймгийн ХЗЭ-ийн хорооны товчоог 9 хүнээр, шалган байцаах комиссыг 5 хүнээр сонгов.

Аймгийн эвдлийн хорооны товчооны гишүүнээр Д. Гонгор, Ж. Жадамбаа Д. Цэрэндаш, Ц. Мянганбуу, Магсаржав, Д. Бямбаа, Гончиг, Галсандорж, Чойсүрэн нарыг сонгож аймгийн эвдлийн хорооны 1 дүгээр нарийн бичгийн даргаар Ж. Жадамбаа, 2 дугаар нарийн бичгийн даргаар Гонгор нарыг батлав.

ШЕФ НЭГДЭЛДЭЭ ТУСЛАЖ БАЙГААНЬ

БНМАУ-ын Соёлын Яамны хамт олон, «Төл нэг бүрийг мал болгоё» гэж намзасаас дэвшүүлсэн лоозонг биелүүлэхээр шеф нэгдлийнхээ мал өвөлжилт, төлийн бэлтгэлийн дуу-ууг хангах ажилд үзэл суртал, эд-материал, хүн хүчний талаар бичилсэн тусалцаа үзүүлж байна.

Соёлын Яам өөрийн шеф Саруул-амьдрал нэгдэлд 19 хүн, 7 машин-тай сурталчилан туслах бригадыг 14 хоног ажиллуулжээ.

Хичээнгүй ахлагчтай энэ брига-дынхан Булган аймгийн Бүрэгхангай сумын нутгаас 4-6 метрийн шургааг 3454 ширхгийг малын суурь, бри-гадад тээвэрлэн зөөж, төлийн тэ-жээлд зориулан хужир шүү 8 тонн, өвс 48 тонныг өвөлжөө хаваржаанд нь буулган өгчээ.

Энэ бригадынхан тус нэгдлийн 75 суурь хотоор явж малчдын ажил байдалтай танилцаж тэдэнд малын төл бойжуулах аргыг тухай яриа таниулга хийсэн байна.

Тус бригадын Нацаг, Гөндөнжав, Баатар нар өөрсдийнхөө санаачил-гаар «Уул худаг» гэдэг газар өвөлжиж байгаа Лувсандагын суурьт төлийг хөрөвжилтийн үе

шатаар бойжуулах үлгэр жишээ байр барьж өгчээ.

Соёлын Яамны хамт олон энэ нэгдэлд баруу, тугалын 675 нэмнээ, 2 уут, 121 сав шуудай, 6 пүнз тусалсан байна.

Шеф байгууллагынхаа хийж өгсөн энэ их тусламжинд нэгдэлчид баяр-лаж мал сүргээ онд тарган оруулж гарсан төлөө мал болгохын төлөө урам зоригтой байгаагаа илэрхий-лээд Соёлын Яамны хамт олонд цаашдынхаа ажилд их амжилт олохыг хүсэн ерөөжээ.

БНМАУ-ын Барилга, Барилгын материалын үйлдвэрийн Яамны харъяа барилгын зургийн институтын захиргаа өөрийн шеф Хөгжлийн зам нэгдлийн мал өвөлжилт, төл бойжуулах ажилд сайхан тусламж үзүүлэв.

Тэд энэ нэгдлийн 2 машиныг за-саж ажилд оруулж, 1 машиныг 15 хоног ажиллуулан, 20 тонн өвс, 200 ширхэг шургаагийг мал төлөх газарт нь буулгажээ.

Төлийн 50 нэмнээ, 200 өлгөвч, төл бойжуулах арга ажиллагааг хэрүүлсэн зурагт хуудас зэргээр тусалсан байна.

НАМЫН ГИШҮҮДИЙН ХҮЧЭЭР

Баян сумын намын үүр, тайлан сонгуулийнхаа хурлын үеэр гишүү-дийн хүчээр ХБ ангийн төлөвлөгөөт зүйлийг нь биелүүлэх ажил зохиов. Үүнд 520 кг яс, 200 кг зэс, гуудь, 200 кг хөнгөн цагаан, төмөний 5 жээ.

М. Сүрэнжав

Малаа өсгөв

Баяндэлгэр сум, 1961 оны мал өсгөх төлөвлөгөөг сумын дүнгээр 101,5 хувь, Хэрлэн-баян нэгдэл 105,1 хувиар тус тус биелүүлжээ.

Чойжамц

ИНГЭЖ ТУСЛАЖ БАЙНА

БНМАУ-ын Банкныхан Баяндэл-гэр сумын Хэрлэн-баян нэгдэлтэй 1959 оноос эхлэн шефийн холбоо тогтоож соёл техникийн талаар байнга туслаж байгаа юм.

Энэ жилийн зудтай байгааг ан-хаарч шеф нэгдлийнхээ мал өвөл-жилтөнд үзэмж тусалцаа үзүүл-жээ.

Саяхан улсын банкны жолооч

Цэрэнсамбуу, Гомбожав нарын 3 жолооч 8000 кг хивэг, уут, өлгөвч, нэмнээ 130 гаруй, 1500 литр бен-зин багтах сав, 20 хос өсгий гу-тал, 30 кг лаа, 10 ширхэг төмөр малтуур зэрэг 6000 шахам төгрө-гийн зүйлийг үнэ төлбөргүй тусал-жээ.

Б. Баярхүү



Баян-чандмань сумын Ла-чинжав ахлагчтай СХТ бри-гадынхан 1961 оны талх үйлд-вэрлэх тө-лөвлөгөөг 3 хувиар давуулаж биелүүл-сэн юм. ЗУРАГ ДЭЭР: Лачин-жавын бригадын-хан ажлаа зөвлөж байна.

Тогтоол шийдвэр заавал биелэх ёстой

Социализмыг эх орондоо өрнүүлж байгуулж байгаа одоогийн нөхцөлд албан аппаратын үйл ажилыг улам шуурхай, хамтын удирдлагын зарчмыг биелүүлж, ажлын хариуцлага, сахлага батыг өндөржүүлэх явдал чухлын чухал асуудал билээ.

Тус аймгийн нам улсын байгууллагын удирдах хариуцлагатайудын ажлаа зарчимч байдлыг хир эрэг баримтгаж байгаа нь дээд байгууллагуулаа тогтоол шийдвэрийг аль хир нарийн чанд биелүүлж байгаагаар хэмжигдэх ёстой. Гэтэл манай зарим байгууллага түүний удирдах нөхөд дээд байгууллагын тогтоол шийдвэрийг биелүүлэх талаар онцгой дутагдал гаргаж байна.

1961 онд аймгийн намын хороос гаргасан хэд, хэдэн тогтоол жинхэнэ ажил хэрэг болсонгүй.

Радио, хөвдөлийн шүүмжлэлийн мөрөөр ажиллах ажлыг сайжруулах тухай гаргасан тогтоолыг аймгийн хөдөө аж ахуйн хэлтэс, сумын захиргаанаас олон түмний ажлыг хэрхэн зохиож байгаа тухай гарга-

сан тогтоолыг «Зуун мод» хотын хороо захиргаан дээр шалгаж үзэхэд энэ байгууллагууд уг тогтоолыг биелүүлэх ч байтугай уншаа ч үгүй байв.

Сэхээтэнтэй ажиллах ажлыг сайжруулах тухай гаргасан тогтоолыг Баянцогт суманд, БХХ нийгэмлэгийн ажлыг сайжруулах, хөдөлмөрдийг хүнсний ногоогоор хангах тухай гаргасан тогтоолуудыг аймгийн БХХ нийгэмлэгийн зөвлөл, аймгийн төвийн худалдаа бэлтгэлийн анги дээр шалгаж үзэхэд зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ аваагүй байв.

Энэ бол манай аймгийн төв орон нутгийн зарим байгууллагын удирдлагууд төвлөн удирдах бсыг хортойгоор зөрчиж дээд байгууллагын шийдвэрийг биелүүлэхгүй, хөдөлмөрчидтэй өдөр цаг тутам ажиллах ажлыг хохируулж байгаа ноцтой дутагдал мөн.

Ийм байдлыг эрс шийдвэртэй засах нь одоо үеийн чухал зорилт болж байна.

Д. Чулуун

Дулаан хашаатай айл

Бид тэжээлийн тарган морьд унаж пасан хунгар хагалуудан дахих явтал Хөндлөнгийн нурууны нэгэн атирааны эхэнд олон хонь тогтоон идэшлүүлж хажууд нь зоримор маягийн настайвтар хүн морио хөтлөн түргэн алхалж харагдах нь үнэхээр шаламгай ажиллагаатай малч хүн гэдэг нь хоромхон зуур ажиглагдав.

Нөгөө хүнтэй билчээр дээр уулзаж мэнд мэдэлцэн ажил төрлөө ойлголцож, цаг зурын байдал, энэ төрийг ярилцаж танилцав.

Та нар манайд оч. Манай гэр хойт энгэрийн хонхор жалгын эхэнд гэж нөмөр дулаан энгэрийг заав.

Энэ бол Өндөрширээт сумын Хөгжлийн зам нэгдлийн 2 дугаар бригадын хоньчин Цэрэндагвын ажээ.

Цэрэндагва гуай, өнгөрсөн жил 600 гаруй бог мал хүдэлн авч намар сайн тарга хүч авахуулаад онд манд оруулахаар хамаг хүчээ дайчлан ажиллаж байгаа төргүүний малчны нэг юм.

Эднийх соргог сайхан билчээртэй нутагт саравчтай дулаан хашаа

барьж хэвтэр бууцаа сайн насвад 2 нуруу өвс, 2000 гаруй кг хужир бэлтгэн авч билчээрийг ээлжлэн ашиглаж, малаа тогтмол хужирлан ядарч доройтох шинжтэйг нь тэжээж байна.

Хоньчин Цэрэндагва гуай, сүүлийн хэдэн жил нэгдэлдээ ан агнах, мал хариулах зэргээр ажилласны үр дүнд хангалуун сайхан амьдарч байгаагаа яриад цааш хэлэхдээ:

Манай эндэх шиг мод ховортой газар малд саравчтай хашаа барихад амаргүй боловч сайн оролдоол болох юм.

Би хотныхоо хойт талыг өндөр эрэг гаргал хуав.

Тэгээд зөвхөн саравчийг модоор хийж, өвс зулаад салхин талд нь өвс нуруудлаа.

Энэ нь маш дулаан хашаа болж байна.

Цэрэндагва гуайн хашаа нь үнэхээр мал даарх аргагүйгээр баригдсан нь бахдууштай.

Эднийх шургуу хөдөлмөрийн үрээр өвлийн хатуу улирлыг аймшиггүй туулах найдвартай болжээ.

З. Дорж

Хувийн бэлэг илгээв

Улаанбаатар хотын уурхайчдын жолосч Пунцагийн Дамбасүрэн, Сүхбаатарын зам нэгдлийн ерөнхий хороонд төлийн бэлтгэлд зориулан хувисаа 20 элгэвч, хурганы 1 уут, төргүүний төлчин гэсэн дарцаг, захиалын хамт илгээж 1962 онд гарах төл нэг бүрийг мал болгох тэмцэлдээ их амжилт олохыг нэгдэлчдэд ерөөжээ.

Энэ бол 1962 онд гарах төлийг хорогдолгүй бойжуулах ажилд бүх нийтээрээ оролцохыг уриалсан МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг биелүүлэхийн төлөө хүн бүхэн санаатайж манай ажилчин анги, хоршоолдсон ардын холбоо бат байгаагийн нэг баримт мөн.

Аюуш

Манай засгийн газрын ордны шинэ барилга

НАМЫН ГИШҮҮНИЙ МАНЛАЙЛАЛ

Заамар сумын ХБ-ийн ангийн түүхий эдийн өрхлөгч намын гишүүн Доржпалам ажилдаа махруу, үлэмж санаачлагатай ажилладаг.

Доржпалам, түүхий эдийн өрхлөгчээр энэ суманд 6 жил ажилладаг уясын бэлтгэлийн төлөвлөгөөг чанар сайтай нэр төрөл дээр биелүүлж иржээ.

Үүний гол учир нь олон түмэнтэй холбостой, тэдэнд зааж сургаж байдагт оршино.

Түүхий эдийн өрхлөгч, өөрөө арьс шир, ангийн үс, хөлдүүгийн зүйл, ноос, хялгасны чанарыг сайжруулахын өдийн засгийн ач холбогдлыг хөдөлмөрдийн дотор ухуулгын олон хэлбэрийг ашиглан цуцалтгүй тайлбарлан таниулдаг байна.

Тэгээд тэр зааж таниулснаа дагуу чанартай зүйлийг хүлээн авдаг билээ.

Доржпалам өөрийн агентуудад 7 хоногт 3 цагийн семинар тогтмол өгч түүндээ арьс ширийг халимлах, зөв өвхөх, төлийн арьсыг давслах ангийн үсийг хангадах, ноосыг сээтэгдэж хог, өвсийг цэвэрлэх аргуудыг үзүүдэн заадаг болохоор агентууд нь түүний барилыг эзэмшиж байна.

Доржпалам бэлтгэлийн зүйлийн чанарыг дээшлүүлэн ноос түүхий

эдийг тэвэрлэхтэй холбогдсон хэд хэдэн шинэ зүйлийг санаачлан хийжээ.

Машинд ноос, түүхий эд ачих гар ажиллагааг хөнгөвчлөн налуу вандан хийснээр 1 хүний хүч хэмээж ачих цагийг 1 дахин багасгаж, хөдөлмөрийн бүтээлийг нэмэгдүүлсэн байна.

Тарианы анжисны барилу, дугуй, бул зэрэг хялгас ашиглан давс нутаглах багаж хийснээр нэг өдөрт гараар 100 кг давс нутаглахыг өдөрт 400 кг давс нутагладаг болгожээ.

Идшинд хэрэглэн, улсын бэлтгэлд тушаасан ямааны арьс 50 гаруй самнаж арьс бүрээс 150 г. ноолуур ашигласан байна.

Доржпалам төрөл бүрийн ноосны чанар дугаар, үнэ, тушаах хугацааг харуулсан үзүүдэний тусгай буланг агуулахдаа байгуулж арьс шир, ноос үс, хөлдүүгийн зүйл, ангийн үс тушаахаар ирсэн хүмүүсэд байнга тайлбарлан таниулдаг байна.

Доржпаламын ухуулга, хөдөлмөрдийн дунд тусгалаа олж тус сумын хамт олон, улсын бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлэх, чанарыг сайжруулахад ихээхэн анхаардаг болжээ.

Заамар нэгдлийн 1961 онд тушаасан арьс шир, 49,6 хувь, хөлдүүгийн зүйл 32,2 хувиар тус тус чанар нь дээшилсэн байна.

Доржпалам нилгэж шинийг санаачилж хийснээр ангидаа 500 гаруй төгрөгийн хэмнэлтийг оруулжээ.

Д. Дондогдорж

5570 ЛИТР ШАТХУУН ХЭМНЭСЭН ХҮН

Манай Нямаа ч аргагүй л ажилсаг хүн дээ.

Ийм хүн төргүүний байхгүй яахав даа гэж Баялдэлгэр сумынхан ярилцадаг.

Н. Нямаа тэр сумын МААМ станцад тракторч камбайчаар ажилладаг юм.

Анх 1959 онд «ДТ-54» трактор бариад гарахдаа Нямаа, тэр жил 817 га газар хагалж төлөвлөгөөгөө 126 хувиар, «СК-3» камбайнаар 128 га газрын ургац халаж 996 центнер үр тариа хурааж 270 литр шатхуун хэмнэжээ.

1960 онд хөрс боловсруулах тө-

төлөвөөг 110 хувь, үр суулгаат 113 хувь, тариа хураалтыг 150 хувиар биелүүлэн 1400 литр шатхуун хэмнэсэн байна.

1961 онд 1583 га газрын хөрс боловсруулж 241 га газрын тариа хурааж 3900 литр шатхуун хэмнэжээ.

Тракторч Нямаа, 3 жил дараалан трактор эзэмшихдээ харуцсан техникээ хайр гамтай өдлөж үргэлж эрчиж цэвэрлэн, «ДТ-54» тракторыг их засваргүй 3714 цаг явуулж нормоос нь 1814 цаг илүү ажиллуулсан юм.

Трактор, комбайныг сул зогсоохыг аль болохоор цөөрлөж 12-24 цаг ажилдуулаад, үзлэг цэвэрлэжээ хийдэг байна.

Одоо хаврын тариаланд бэлтгэн, өөрийн эзэмшигдээ машинууддаа засвар үйлчилгээг хийж дуусав, улмаар «ДТ-54» трактор 13, белорусс 7, уулын трактор 1-ийг засалцав.

Тракторч Нямаа, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Цэрэн-очирын туршлагыг эзэмшиж, урьд онуудад олсон амжилтаа улам бататган 1962 онд хөдөлмөрийн баатарын болзол хангах зорилт өмнөө тавин ажиллаж байна.

Цэрэндорж

Номын сан.

Ботго бойжуулахад анхааръя

Тэмээ бол хээлийн ба хөхүүд үе нь урт, бараг ихэрлэдэггүй мал учир тоо толгойн өсөлт нь удаан байдаг. Ийм учраас ингийг бүрэн хээл авахуулах, хээлийг нэг бүрчлэн хамгаалах, гарсан ботго бүрийг хорогдоогүй бойжуулах нь нэн чухал юм.

Манай оронд ингэ 2 дугаар сарын сүүлчээс 4 дүгээр сарын эхний хагаст ид ботгодог.

Ботгодох шахсан ингэ голдуу шилэрч яваад эзлүүд газар ботгодог ботго нь осолдох явдал цөөнгүй байдаг.

Иймд хээлтэй ингэний өдрийн хариулга, шөнийн манааг эрс сайжруулах ёстой.

Ингэ 1-1,5 сарын урьдаас дэлгэж гуяны дотор тал, дэлэнгийн үс халцарч ботгодох дөхсөний тэмдэг үзэгддэг.

Ингэхдээ ботгодох шахсан ингийг гэрийн ойр байлгаж гаднаа ботголуулах нь чухал бөгөөд ботго бүрийг эх барьж авах шаардлагатай.

Ингэ ботгоо долоодоггүй учир эхээс дөнгөж гараад байгаа ботгоны ам хамрын салсыг цэвэрлэж үсийг өгштөл давуу, зөөлөн өвсөөр арчино.

Ботго бусад малын төлийг бодвол маш сул дорой төрдөг учир анхны босолт, амлалтанд нь хүний туслалцаа хэрэгтэй байдаг.

Ботгыг гарсанаас хойш 1,5-2 цаг болоод амлуулна.

Амлуулахын урьд өхийн дэлэн, гуяны дотор талыг бүлээн цай буюу усар угааж цэвэр давуугаар хуурай болтол арчаад хөхний бөглөөг гаргана.

Амлуулахынхаа өмнө ботгонд 200-300 гр хиртэй бүлээн шингэвтэр хар цайнд 15-20 гр шар тос хайлуулан угжвал ботгоны гэдэс хоолооны ажиллагаа сайжирч зунгаг нь түргэн гардаг юм.

Нялх ботго тун бээрэг байдаг болохор эхээс гармагц дулаан хашаа, хороонд байлгаж амлуулсны дараа нэмнэвэл зохино.

Амлуулахын урьд нэмнэвэл өх нь голж илүү ажил удахад хүрнэ.

Нялх ботгонд өхийн уургийг олон дахин бага багаар хөхүүлэх ёстой. Уураг сүү бол Сотгонд юугаарч сольшгүй унут тэжээл бөгөөд ингэний уураг 5-7 хоног үргэлжилдэг байна.

Уургаа бүрэн хөхсөн ботго түргэн торихоос гадна, эрүүл чийрэг бойждог учир ингийг эхний сард сааж үл бодно.

Ботго эхний 21-30 хоногтоо толгой нь газар хүрч намхан өвс ургамлыг идэж чаддаггүй учир өвсөнд орж эхэлж байгаа ботгыг зөөлөн дэрс, бударгана, заг, суль зэрэг өндөрхөн ургамалтай газар аргажиж сургах нь зүйтэй юм.

Ботгыг хужир шөрвөгөөр тасалж болохгүй.

Хужирсан ботго өөрийн бээхийн үс, уяа, ээл зэрэг хатуу зөөлөн юм мэрх, хөхөж өвчлөхөд хүрнэ.

Ботгыг өвсөнд орох хүртэл буюу эхний 15-20 хоногт өргүүлж сайтай уяагаар өвдөглон уяж 2-3 хоногийн зайтайгаар хөлийг ээлжлэх хэрэгтэй.

Харин ботгыг өвсөнд орохын хамт нэгт хийж уяна.

Ногоо гарч ингэ холын билчээрт гарахын хамт ботгыг тавьж билчээрлүүлнэ.

Энэ үед ботгоны билчээрт өөр төрлийн мал явуулж үл болно.

Ботгоны билчээрлэх газар нь хөрс зөөлөнтэй, шивээ, зингуу, шумуул, хөх түрүүгүй, сэрүүвтэр, бор шар бударгана, бор шавга, хялгана, хнаг, баглуур, сультай байвал зохино.

Ботгыг тавьж эхэлснээс хойш өдөрт 3 удаа хөхүүлнэ.

Зуны улиралд ботгыг өдөрт 2-оос доошгүй усална.

Зун намрын улиралд ботгыг сайн тарга хүч авахуулбал дараах өвөл хавар нь эцэж турах нь бага байдаг.

Ботгыг ширүүн оролдож зодож болохгүй.

Тэгвэл дошгин ширүүн мал болно.

Зоо-техникч Даваадорж

Нүд хурц, буу цэцэн

Заамар суманд ан гөрөөний арга барилыг чадмагтай эзэмшсэн анчин аалдартай Лувсандорж бий.

Анчин Лувсандорж төрөл бүрийн ан амьтны нутаг байршиллыг урьдчилан гойд судлаж, газрын өө бартааг сайн ажиглана.

Үргэх, өнгийх, гүйдлийн нь тосч суух, мөрдөх аргуудыг хэрэглэнэ. Буудахдаа мэргэн нь гоц.

Анчин Лувсандорж нь зөвхөн өөрийн сумын нутгаар төдийгүй Сэлэнгэ аймгийн Орхон-туул, Булган аймгийн Бүрэгхангай, Халиун сумын нутгаар явж гур, зур, шилүүс, чоно, дорго зэрэг ан агнадаг. Лувсандорж чандага, туулай, нохой, шувуу, зурам, томин зэрэг жижиг анг голомгүй агнаж сумныхаа бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлэхэд их тус хүргэдэг юм.

Лувсандорж сүүлийн 10 жилд тарвага 1200, зурам 500, үнэг 135, хярс 104, туулай 200, дорго 25, зээр 25, мануул 26, өмхий хүрэн 10, чоно 140, нохой 80, шувуу 600 г агнаж улсын бэлтгэлд тушаажээ.

1961 онд үнэг 14, чоно 8, зээр 4, шувуу 60, туулай 40, мануул 6, нохой 10, тарвага 80, зурам 36, шилүүс нэгийг агнажээ.

Лувсандорж ярихдаа: 20 шахам жинд анагнаж байна.

Тэхдээ ангийн ажлаар үргэлж хөөцөлдөөд байдаггүй.

Нэгдэл маань намайг гартаа дүйтэй хүн гээд барилгын ажил хийлгэдэг.

Энэ жил 2 хүнтэй хамтарч 4 айлын орон сууцны 2 байшин барив.

Энэ жил ажлын зав чөлөөгөөр мордож, га ц нэг буудсандаа гээд цааш хэлэхдээ: Намайг ан гөрөө хийж явахад янз бүрийн сонин зүйл тохиолддог юм.

Саяхан манай дарга Аюурзана, БНМАУ-ын Их Хурлын депутат Жамъяншарав бид 3 өвөлжөөний нутаг үзэхээр Заамарын хойт ууланд явж байтал нэг шилүүсний мөр дайралдаад түүнийг мөрдөөд явав.

Гэтэл тэр шилүүс маань нэг туулай идэж орхнод толгойгүй нь үлдээгээд явчихсан байлаа.

Бид цааш нь мөрдсөөр яваад голын бургас руу ортол нохой гаслав. Тэгээд нарийн ажиглавал нөгөө шилүүс чинь унтаж хэвтсэн чонотой таарч ноцолдож байгаа нь харагдав.

Тэр хоёрыгоо давхраар нь намнаж авлаа.

Ер нь шилүүс гэдэг амьтан мөн ч ууртай юм шүү дээ гэж ярьж билээ.

ЗУРАГДЭЭР

Анчин Лувсандорж ангийнхаа үсийг тушаахаар сорьсны сэрлээг гээж байна.

(Д. Дондогдоржийн гэрэл зураг).



Туршлага судалсан нь

Торой бордох шинэ арга

Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн сангийн аж ахуйд гахайн торой бордогчоор намын гишүүн Равжаа ажилладаг юм.

Энэ хүн гахай малласан хугацаандаа тэжээл маллагаанд нь нарийн ажиглалт хийж торойг хүйтэн хоолоор тэжээх аргыг санаачлан оршсан нь амжилт олжээ.

Гахайгийн Равжаа торойг эхээс гараад 15 хоносны дараа хүйтэн хоолоор тэжээсэн байна.

Ингэхдээ торойн байрыг тогтмол 8-10 градусын дулаан байлгаж хэвтрийг өдөр бүр сольсон нь хүйтэн хоолны шингээлд сайн нөлөө үзүүлжээ.

Торойн хоол боловсруулах эрхтний ажиллагааг сайжруулах зорилгоор эхээс гараад 18 цаг болсны дараа, хар улаан шороо, мод, ясны нүүрс, төмрийн хүчил идүүлвэл хүйтэн хоол шингэхэд сайн нөлөө үзүүлдэг байна.

Хүйтэн хоолыг тогтмол, цагийн хувиарыг хатуу баримтлан бага багаар өгөх нь ашигтай юм.

Равжаа торойгоо үүний урьд халуун хоолоор тэжээж 1 торойнд өдөрт 1 кг хоол өгч, дунджаар 13,5 кг амьдын жинтэй эхээс салгадаг

байсан бол 1961 онд нэг торойнд өдөрт 400-500 гр хүйтэн хоол өгч нэг торойг 14,5 кг амьдын жинтэй эхээс нь салгажээ.

Ингэхдээ гахайн торойг элдэв өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж чадсанаар 11 мэгжээс 253 торой бойжуулан авчээ.

Торойг хүйтэн хоолоор бордосноор хоолчанаж бэлтгэгчийн орон тоог хасаж түлшний зардлаас 10500 төгрөгийн хэмнэлт гаргажээ.

Төрөлжсөн агуулах

Зүүнхараагийн сангийн аж ахуйд, авто ба хөдөө аж ахуйн машинуудын төрөл бүрийн запасыг хадгалах агуулах хийжээ.

Энэ агуулах 300 хавтгай дөрвөлжин метр багтаамжтай юм.

Энэ агуулахад авто машин, трактор, комбайн, цахилгаан гагнуур, хөдөө аж ахуйн машинууд гэх мэтээр 14 хэсэгт төрөлжүүлсэн нь сэлдэг хэрэгтэйг өмх журамтай, хайр гантай зарцуулахад сайхан боломжийг өгчээ.

Түүнчлэн запас бүрийг орлого зарлагын хуудастай болгон запас бүрээс зүүсэн нь уул агуулахын тооцоог нарийн шуурхай болгож өлдөөн запасыг агуулахаас өрж цаг гаргахгүй болгожээ.

Манай аймгийн бүх сангийн аж ахуй ойрын үед нйм төрөлжсөн агуулахтай болох талаар бололцоо бүхнээ ашиглавал зохино.

Гэрийн ясли

Улаанбаатар хотын илчт тэргүйн депюгийн Жаңцан ахлагчтай СХБ-ын гишүүд өөрсдийн гишүүд, тэдний гэр бүлийн хүмүүсүүдийг ажилд бүрэн оруулах зорилгоор гэрийн ясли байгуулжээ.

Энэ яслид 10 гаруй хүүхэд тавтай сайхан саатаж байна.

Бригадын гишүүд өөрсдийн санаачлагаар яслидаа асрагч, тогооч хэр хүнийг ажиллуулж түүний цалин, хүүхдийн хоол хүнсний зүйлийг дундinxаа фондос гаргадаг журам тогтоожээ.

Ингэж хүүхдийн яслийг байгуулах туршлагыг манай сангийн аж ахуйнуудын СХБ ба СХТ бригадууд өргөн хэрэглэх нь чухал байна.

Б. Цэрэндаш

14 УЛИРАЛ ДАРААЛАН ОНЦ

Баяндэлгэр сумын бага сургуулийн 4 дүгээр ангийн сурагч Ичинхорлоо, 14 улирал дараалан онц сурагчжээ. Сурагч Ичинхорлоо багшийн заасан хичээлийг анхааралтай сонсож гэрийн даалгаврыг хичээнгүйлэн хийхдээ хувийн төлөвлөгөө, цагийн хувиарыг хатуу баримтладаг байна.

Энэ нь зөвхөн амна хичээлдэггүй, нөхөддөө тусархаг, өөрөө нөхдөөсөө их сурдаг юм. Сурагч Ичинхорлоо, 5 онцыг эзэмшихийн тулд хөгжим, дуу олныг сурч, хөдөлмөр батлан хамгаалахад бэлхэн тэмдгийн номыг хангах бэлтгэлийг хийгээд байна.

Мөн хичээлээ давахын зэрэгцээгээр хүүхдийн зохиол «Зоригт оёдолчин» гэх зэрэг хүүхдийн 4-5 ном уншжээ. Ичинхорлоо 16 улирал дараалан онц сурахын төдөө бүх хүчээ дайчлаж байна. Ж.Цэрэндорж

Гахай маллагч

Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн сангийн аж ахуйд гахай борлогчоор Дүрээ ажилладаг юм. Гахайчин Дүрээ гахай төлүүлэгчдээс 4 сартай тойрог хүлээн авч борддог ажээ.

Ингэхдээ дуйл, халгай, яс, махны гурил, булаа зэргийг хоолны үлдэгдэлтэй нутаглан хольж гахайгаас өдөрт 3 удаа хооллож өдөрт 7-10 удаа шингэн зүйл өгдөг байна.

Энэ нь хоол боловсруулах эрхтний ажиллагааг идэвхжүүлж идсэн зүйл нь сайн шингэж, гахайн өсөлт тэргэнд сайн нөлөө үзүүлдэг байна.

Гахайд нэг янзын төжөөл өгөх нь муу, өдөр бүр төжөөлийг өөрчилж өгөх нь ашигтай юм.

Гахайд спиртын шаар өгөх нь ашигтай боловч хэт ихээр өгвөл гахайн ходоодыг харлуулж, хоол боловсруулах эрхтний ажиллагааг муутгаж өнгө зүсийг нь алдуулдаг гэнэ.

Гахай бордож байгаа хүн ширүүн

авир зангаар гахайнуудтайгаа харьцах, төжөөлийг нь цагт нь өгөхгүй хожимдуулбал гахайн уур хурч зүрх нь хагаран үхдэг ч удаа тохиолддог гэнэ.

Гахайн хөвтрийг байнга цэвэрлэж байвал гахай, хөвөн шиг цэвцгэр дун цагаан өнгөтэй болдог. Хөвтрийг солилгүй удвал өнгө нь шаралдаг учир дэвсгэрийг өдөрт 2-оос доошгүй удаа солидог байна.

Гахайн байрыг 18-аас доошгүй градусын тогтмол дулаанд байлгахгүй бол гахай цусан хатгалга тусгах, дотор нь эвгүйцэж өвчилдөг гэж алдарт гахайчин Дүрээ гуай ярилаа.

Гахайчин Дүрээ ингэж уйгагүй ажилласны дүнд 7 сартай тойрог 70 хоног бордож 70 кг жинтэй тушаах нормтойг 45 хоног бордож 120 кг-ийн жинтэй тушаадаг сайхан туршаагатай болжээ.

Б. Цэрэндам

Цахилгаан ашиглалт, үйлчилгээг эрс сайжруулъя

Цахилгаан гэрлийн урсгалын хаягдлыг багасгаж түүнд аж ахуйчаар хандах нь тус аймгийн нийт байгууллага, хүмүүсийн эрхэм аорилтын нэг байх ёстой.

Тус аймагт албан газруудын уурын зуух, элдэв моторт хэрэглэл, хөдөлмөрдөөс цахилгаан гэрэл хэрэглэх хэрэгцээ өдөр дутам өссөөр байна.

Гэтэл цахилгаан шугамыг дур зоригороо залгаж, таслах, зөвшөөргүй байгаа зэрэг нь улсын үнэт хөрөнгөнд хүйтэн сэтгэлээр хандаж байгаагийн илрэл мөн.

Албан байгууллага, эвгийн айллуудын гэрэлд хяналт тавих үүрэгтэй аймгийн цахилгаан гэрлийн станцын удирдлага, зохих үүргээ муу биелүүлж байна.

Тэдэнд цахилгаан ашиглалтын аж ахуйн нарийн тооцоо одоогоор алга байна.

Иймээс гэрлийн үнийг дутуу хураах, цахилгааныг зөв зохистой ажиллуулахгүй байн байн унтрааж асаах зэргээр хэвийн байдлыг алдагдуулж үргүй зардал гаргах, зөв албан газарт унтраалгагүй гэрэл тавьж цаг үргэлжид асаалттай байлгаж цахилгааны урсгалыг үр ашгийг зарцуулж байгаа явдал үзэгдэнэ.

Цахилгаан станцынхан гэрлээр нийтэд үйлчлэх үйлчилгээг шуурхай болгож, цахилгаан гэрэл ашиглах тухай дүрмийг хатуу биелүүлэх хэрэгтэй.

Гэрэл ашиглалтын дүрмийг цахилгаан ашиглагчдад бүрэн ухамсарлуулахын хамт цахилгаан станцын ажилчдын техник мэрэгжлийг дээшлүүлэх талаар бүтээлч арга хэмжээ авбал зохино.

Лувсандорж

Хөдөлмөрдийн захидлаас

Залхуу механикч

Баяндэлгэр сумын кино механикч эвлэлийн гишүүн Түмэнбаяр залхуу хойрго нь хэтрээд хөдөлмөрдийг киногоор үйлчлэхийг бараг больжээ.

Хавьяа нэг кино гаргавал зарладаггүй, зарлавал гаргадаггүй өвчтэй болжээ.

Түмэнбаяр 1 дүгээр сарын 2-ны өдөр 20 цагт кино гарна гэж зарлаж хүмүүс цуглуулаад өөрөө ир-

сэнгүй. Отор нүүдлийн үеэр Хэрлэн голын дээд гүүрийн сууринд кино гаргана гэж очсон боловч мотор муу гэдэг нэрээр сар шахам ажилгүй байв.

Ийм хариуцлагагүй залхуу механикийг удирдах байгууллага нь анхаарууштай юм.

Ц. Чойжамц

БНАГУ-ын Гадаад Явдлын Яамны төлөөлөгчийн мэдэгдэл

БЕРЛИН, 1 дүгээр сарын 20. (МОНЦАМЭ). Бонны Канцлер Аденауэр, ХБНГУ-ын ерөнхийлөгч Любке, Эрвэд Германы сайд Шварц нар баруун Берлинд ирэх гэж байгаа тухай өрнөдийн хөдөллийн мэдээлэлтэй уялдуулан БНАГУ-ын гадаад явдлын яамны төлөөлөгч мэдэгдэл хийсэн байна.


Баруун Берлиний асуудлыг энх

тайвнаар зохицуулах боломжийг хөдөлгөж байгаа олоо үед Бонны болон баруун Берлины улс төрийн зүтгэлтнүүд уг хөдөлгөөг хүмдрүүлэхийг оролдож байгаа нь "илэрхий" билээ.

Тэд баруун Берлинийг фронтын хот болгон ашиглаж олон улсын хурц байдлыг зөөдрүүлэхэд саад учруулахыг оролдож байна гэж уг мэдэгдэлд дурджээ.

Мөн мэдэгдэлд заахдаа Өрнөдийн гүрнүүд баруун Берлинд өдөөн хатгаж очиход нисэх онгоцоо хууль бусаар ашиглуудан уг аюултай ажиллагааг өгтшүүлж байгааг анхаарахгүй байж болохгүй.

Иймэрхүү ажиллагаанаас гарах уршгийг төд харгалзах ёстой гэсэн байна.



ЗУРАГ ДЭЭР: БНБАУ-ын Ловеч хотын хоршооллын аж ахуйн гахайн шинэ байр. Энд 4000 гахайг 3 хүн хариулж малладаг байна.

(Болгараас ирсэн гэрэл зураг)

Малын бага эмчийн бодлогошрол

(Бяцхан тохмо)

Идэр гурван өсийн хүйтэн жавар хацар нүүр хавцрын нэг өдөр Оорцогийн уулын баруун хажууд өвөлжиж байгаа хот айлын гадаа хурган малгай хулгавчлаа, хоёр гаргаа зөрүүлж атгасан бүдүүвэр, хонины дэргэд уйтгарлан зогсоно.

Энэ бол Эрдэнэсант сумын 2 дугаар бригадын малын бага эмч Дашдорж, хамуунд баригдаж үс нөөс нь мултраад үхэж байгаа хонидтойгоо салах ёс гүйцэтгэж байгаа нь тэр ажээ.

Дашдорж үнэндээ уй гашуу ч хийж байгаа хэрэг биш харин энэ олон эрлийз хонины хамууг даамжруулснаас хартолгойгоо хэрхэн мултрах тухай л бодлогошрол байгаа нь энэ бололтой.

Би малын эмчийн ажлыг он удаан жил хийж олон газар дамжиж даамжруулснаас хартолгойгоо ороосон дутагдлаас дөөшнээ хэлж, доошоо малтаж өдөнийн арга хэрэглэн мултарсан нь алийг тэр гэхээ дээ.

За байзаа, 10 дугаар сарын 6-наас эхлэн хамуурсан энэ хонийг өнгөрсөн 120 хоногт ямар өмчилгээ хийхээр хэдэн удаа ирсэн билээдээ гэхээр 3 мал.

Эр хүнд зайч бий, лайч бий, тэр үед хамууны эм ховор (дүүст) бол бүрч бага байсан.

Сумын салбарын эмч Дагвацэрэнд 2 удаа, сум-нэгдлийн дарга Дамдингомбод 2 удаа, намын үүрийн нарийн бичгийн дарга Ядамсүрэнд 1 удаа тус бүр амаар хэлсэн бо-

ловч арга хэмжээ аваагүй гэж хэлж нэг үзнэ.

Тэгээд болохгүй бол намрын хайлган цагт хонио ширүүн хөөж хамууруулаад, өвлийн ес эхэлсэн ид хүйтэнд гаднаа атга ч өвсгүй хот хороогоо хөлдөөсөн учраас энэ мал үхлээ гэж хариулав эзэн Чимид руу түлхэж нэг үзнэ.

Бүр болохгүй бол хамуутай хонио ялгаж эмчилбэ гээд байхад хариулах хүн гаргаж өгөөгүй бригадын дарга Гомбодорж руу түлхээд үзнэ.

Ингээд нэг учир бий гэж боджээ. Малын бага эмч Дашдоржийн энэ бодолд ортой юм байвч 100 гаруй хонигт нэгч хонь өмчлөөгүйгээс 727 хонийг баргий нь хамууруулаад ноос ба төлчгүй болж 70 гаруй нь үхсэн нь эмч Дашдоржоос мултрах эмггүй бизээ.

700 гаруй хонио ингэж зөнд нь орхиж гарздаж байгааг Эрдэнэсант сум-нэгдлийн удирдах нөхөд ч хуваалцажгүй хаана зайлхав дээ.

Д. Дондогдорж

Хариуцлагаатай эрхлэгч
С. ДИНСМАА

ЗАРЛАЛ

Цахилгаан гэрэл ашиглагчдын дөвтрийг 1 дүгээр сарын 25-наас эхлэн олгох ба шинээр гэрэл тавина. Гэрлийн үнийг удирал бүрийн өхний сарын 20-ны дотор хурааж дуусгана.

Дурдсан хугацаанаас хожимд-вол торгуул өмгдүүлнэ.

13 дугаар авто бааз.

* * *

Лүү сумын 6 дугаар бригадын харьяат Гомбо овогтой Цогзолмаагийн сэдэвнээр мөн сум-бригадын Дэмбэрэл овогтой Дагваас гэрлэлтээ цуцлуулахаар ирүүлсэн өрөгдлийн аймгийн нүүдлийн-шүүх олрын өдрүүдэд шийдвэрлэх гэж байна.

Төв аймгийн нүүдлийн шүүх.